



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ХАНХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 08 сарын 22 өдөр

Дугаар 8/55

Ханх сум

**Өвөлжилтийн бэлтгэл хангуулах ажлын хэсэг
байгуулах, төлөвлөгөө батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйл 66.1, аймгийн Засаг даргын 202 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн А/306 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын хэмжээнд 2024-2025 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Баттүвшин (Засаг даргын орлогч)

Гишүүдэд:

Б.Баасансүрэн (Засаг даргын Тамгын газрын дарга)

К.Одгэрэл (Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга)

Ж.Батцэцэг (Санхүү албаны дарга)

Ш.Отгонжаргал (Тураг 1-р багийн Засаг дарга)

Б.Анхбаяр (Хороо 2-р багийн Засаг дарга)

Э.Мөнхжаргал (Турт 3-р багийн Засаг дарга)

Б.Бямбабаяр (Баясгалант 4-р багийн Засаг дарга)

Э.Алтангэрэл (Мал эмнэлгийн улсын байцаагч)

Б.Мөнхтөр (Хэсгийн төлөөлөгч)

Д.Анхтуяа (Эрүүл мэндийн төвийн дарга)

Ө.Жаргал (Ерөнхий боловсролын сургуулийн захирал)

Ж.Уранчимэг (Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч)

О.Эрдэнэтулга (Соёлын төвийн дарга)

А.Ёндонпэлжээ (Хилийн 0117-р салбарын захирагч)

Б.Мөнхсайхан (Хийлийн цэргийн 0335-р салбарын захирагч)

С.Сүлд-Эрдэнэ (Ханх сумын эрэн хайх, аврах бүлгийн дарга, аврах ажиллагааны зааварчлагч ахлах дэслэгч)

О.Анхбаяр (Гаалийн хорооны менежер)

Сумын Эрчим хүчний байцаагч

Б.Нэргүй (Ус цаг уур, шинжилгээний албаны ажилтан)

Нарийн бичгийн дарга:

Ц.Саранцэцэг (Засаг даргын Тамгын газрын Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)

2. Мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл хангуулах ажлын төлөвлөгөөг нэгдүгээр, төв

My doc-2024 Zahiramj

8707010168

суурийн газрын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах төлөвлөгөөг хоёрдугаар, албан байгууллага, аж ахуй нэгжийн өвөлжилт хаваржилтийн бэлтгэл ажлыг хангуулах удирдлага арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг байгууллагын хуваарыг гуравдугаар, сумын аюулгүйн нөөцний өвсний хуваарийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

3.Сумын хэмжээнд өвөлжилтийн бэлтгэл ажлыг зохион байгуулж, явцын мэдээллийг Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн дарга, гишүүдэд даалгасугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүй хариуцсан мэргэжилтэн (О.Золзаяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ДАВААБАЯР